



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын  
Засгийн Газар, Бүгд Найрамдах  
Социалист Румын Улсын Засгийн  
Газрын хооронд 1971-1975 онд  
харилцан бараа солилцох ба  
төлбөрийн тухай Хэлэлцээр.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар, Бүгд  
Найрамдах Социалист Румын Улсын Засгийн Газар, эдийн зас-  
гийн хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэн, цаашид хоёр  
орны харилцан бараа солилцох явдлыг нэмэгдүүлэх зорилгоор  
доорхи зүйлүүдийг тохиролцов.

#### I-Р ЗҮЙЛ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Со-  
циалист Румын Улсад, Бүгд Найрамдах Социалист Румын Ул-  
саас Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1971 оны I-р сарын  
I-нээс 1975 оны I2-р сарын 3I-ийг дуустал бараа нийлүү-  
лэх явдлыг I,2-р хавсралтад заасан ёсоор гүйцэтгэнэ. Ний-  
лүүлэх барааны I, 2-р жагсаалт нь энэхүү Хэлэлцээрийн  
салшгүй хэсэг нь болно.

1968 оны IO-р сарын 28-ны өдрийн зээлийн Хэлэлцээр-  
вэр Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Засгийн Газраас  
Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газарт олгосон 3  
сая рублийн зээлээс 1972-1975 онд төлбөл зохих хэсгийг

/ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Экспорт жагсаалт 2-т оруулан бодолцов.

### 2-р зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу гүйцэтгэгдэх жил бүрийн бараа гүйлгээ нь урьд оны II-р сараас хожуугүй хоёр орнуудын хооронд гарын үсэг зурагдах, харилцан бараа солилцох ба төлбөрийн тухай жилийн Протоколын үндсэн дээр гүйцэтгэнэ. Барааны контингентуудын тоо буюу өртгийг дурьдсан Протоколуудад тогтоох байх болно.

Харилцан Нийлүүлэх бараа, төлбөрийн балансын зарчмыг жил бүр баримтлан Талууд нь харилцан солилцох барааны хэмжээг нэмэгдүүлэх, нийлүүлэх барааны нэр төрлийг олшруулахыг эрмэлзэнэ.

### 3-р зүйл

Энэхүү Хэлэлцээрийн I-р зүйлд заагдсан харилцан бараа солилцох ба жилийн Протоколоор бараа нийлүүлэх явдал нь хоёр орны гадаад худалдааны байгууллагуудын хооронд байгуулагдах контракт болон удаан хугацааны контрактыг Протоколд гарын үсэг зурсан өдрөөс хойш 60 хоногийн дотор байгуулвал зохино.

### 4-р зүйл

Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд нийлүүлж байгаа барааг

зөвхөн нийлүүлэгч орны Гадаад Худалдааны Яамтай урдчилан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гуравдахь оронд дамжуулан худалдаж болно.

#### 5-Р ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн нэг зүйл болох хоёр орны гадаад худалдааны байгууллагуудын хооронд жил бүр бараа солилцох ба төлбөрийн тухай хэлэлцээр болон хоёр орны Гадаад Худалдааны Яамдын тохиролцсоноор буюу Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөл болон түүнтэй эрх бүхий байгууллагуудаас үнэ тогтоох талаар гаргасан аргачлал, зөвлөмж, зарчмын үндсэн дээр байгуулсан контрактаар барааны үнэ тогтоогдоно.

Харилцан тохиролцогч аль нэг тал нь контрактын үнийг өөрчлөх талаар эдийн засгийн үндэслэл бүхий санал тавивал, хоёр талын зөвлөлдөөн хийж болно.

#### 6-Р ЗҮЙЛ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Румын Улсын хоорондох энэхүү Хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх төлбөрийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын, Улсын Банк ба Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Гадаад Худалдааны Банк нь " Олон Улсын Эдийн Засгийн хамтын ажиллагааны Банк байгуулах ба шилжих рублийн олон талт тооцооны тухай " 1963 оны 10-р сарын 22-нд Москва хотноо гарын үсэг зурсан Хэлэлцээрийн нөхцөлийн дагуу Олон Улсын Эдийн Засгийн хамтын ажиллагааны Банкны зохих

дансаар шилжих рублээр гүйцэтгэнэ.

#### 7-Р ЗҮЙЛ

Хэрэв шилжих рублийн олоо баримтлаж байгаа цэвэр алтны 0987412 граммтай тэнцэх алтан баталгаа өөрчлөгдөхөд хүрвэл шилжих рублээр тодорхойлогдсон өрийн үүрэг болон бусад төлбөрүүд, уул өөрчлөлт орохоос өмнө байгуулагдаад биелэг - дээгүй буюу дутуу биелүүлсэн контрактын шилжих рублээр илэрхийлэгдсэн дүнд дээр дурьдсаны нэг адил алтны тэнцвэрийг хэвээр үлдэвн зохицуулана.

#### 8-Р ЗҮЙЛ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын, Улсын Банк ба Бүгд Найрамдах Социалист Румын Улсын Гадаад Худалдааны Банк нь энэхүү Хэлэлцээрийн дагуу үүсэн гарах төлбөрийг гүйцэтгэх журмын талаар тохиролцох болно.

#### 9-Р ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг хүчинтэй байх хугцаанд хоёр орнуудын хооронд гүйцэтгэх төлбөрийн нийт хэмжээ нь жил бүр тэнцүү байвал зохино.

#### 10-Р ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр болон жилийн Протоколын биелэлтийг шалгах зорилгоор хоёр орны Гадаад Худалдааны Яамны төлөөлөгчдийн бүрэлдэхүүтэй хамтарсан Комисс байгуулах ба энэ нь

аль нэгэн талын саналаар Улаанбаатар ба Бухарест хотод ээлжлэн цуглана.

Контракт байгуулалтын байдал, харилцан бараа нийлүүлэлт ба төлбөрийн асуудалд лүн шинжилгээ хийхийн хамт энэхүү Хэлэлцээр, жилийн Протоколыг биелүүлэхэд тохиолдож болох бэрхшээлийг арилгах талаар хамтарсан Комисс нь арга хэмжээ авах болно. Энэхүү хамтарсан Комисс нь хэрэгцээтэй үед зохих зөвлөлгөөн өх ба түүнчлэн хоёр орны хооронд бараа солилцох хэмжээг өргөтгөх санал тавьж болно.

#### II-Р ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн заалт нь Хэлэлцээрийн хүчинтэй байхад байгуулсан контракт биелэгдээгүй буюу хагас биелэгдсэн бол 1975 оны 12-р сарын 31-нээс хойш хэрэглэгдэнэ.

#### 12-Р ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь 1971 оны 1-р сарын 1-ний өдөрөөс эхлэн 1975 оны 12-р сарын 31-нийг дуустал хүчин төгөлдөр байх болно.

1971 оны 1-р сарын " 16 " ны өдөр Бухарест хотноо монгол, румын, орос хэл дээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эдгээр эх хувиуд нэг адил хүчин төгөлдөр болно.

Хэрэв ойлгоход зөрөө гарвал орос хэл дээрх эх  
шийдвэрлэгч нь болно.


БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ  
АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗ-  
РЫН ЭРХ ОЛГОСНООР

Д.ЦЭРЭНСАНЖАА



БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ  
ГУМЫН УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫН ЭРХ ОЛГОСНООР

И.СТОЯН





Бүгд Найрамдах Социалист Румын  
Улсаас Бүгд Найрамдах Монгол  
Ард Улсад 1971-1975 онд ний-  
лүүлэх барааны жагсаалт I.

	үнэлэх нэгж	1971	1972	1973	1974	1975
Кальцын сод	тонн	925	965	995	1085	1080
Каустын сод	тонн	300	350	400	450	500
Эмийн зүйл	мян/руб	20	20	20	20	20
Тосон будаг	тонн	650	650	650	650	650
Фанер	куб/метр	380	380	380	380	380
Мебель	мян/руб	100	100	100	100	100
Сүлжмэл эдлэл	мян/руб	150	160	170	180	190
Синтетик хольц- той даавуу	мян/метр	30	40	50	60	70
Гутал	мян/хос	20	20	20	20	20
Ногооны консерв	тонн	100	100	100	100	100
Хуурай жимс	тонн	150	150	150	150	150
Бичгийн цаас	тонн	60	60	60	60	60
Сургуулийн 16 хуудастай дэвтэр	сая/шир	3	3	3	3	3
Цирхийн төхөөрөм- жийн сэлбэг	мян/руб	-	10	10	10	10
Мод цагаалах агаарын дамжуулах төхөөрөмж	мян/руб	-	50	-	-	-
Бусад бараа	мян/руб	250	250	350	350	350



Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас  
 Бүгд Найрамдах Социалист Румын  
 Улсад 1971-1975 онд нийлүүлэх  
 барааны жагсаалт 2.

үнэлэх нэгж		1971	1972	1973	1974	1975
Боловсруулсан						
үстэй нэхий	мян/шир		20	20	20	20
Шеврет	мян/шир	20	20	20	20	20
Тарваганы арьс	мян/шир	10	10	10	10	10
Адууны нойтон давстай шир	мян/шир	6	7	7	-	-
Хонины халуун угаалгын цагаан ноос	тонн	100	100	100	100	100
Тэмээний ноос	тонн	60	60	60	60	60
Бодын хөөвөр	тонн	160	170	180	200	200
Адууны дэл, сүүл	тонн	5	5	5	5	5
Сарлагын сүүл	тонн	15	15	15	15	15
Савхин дээл	мян/шир	10	10	10	10	10
Савхин эдлэл арьсан жижиг бараа	мян/руб	75	125	150	200	200
Нэхий эдлэл	мян/руб	-	75	75	150	150
Хивс	мян/квм	-	10	10	10	10



2.

Хонины мах	тонн	100	100	150	150	150
Махны консерв	тонн	-	-	60	120	120
Хонины өлөн гэдэс	мян/гогц	50	50	50	50	50
Арьс ширний цавуу /7,5 энглер/	тонн	60	60	60	60	60
Бусад бараа	мян/руб	150	150	150	150	150